

**БАТЛАВ. “ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ” ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**

**Т.БИЛГЭЭ**

**Улаанбаатар хот. 2015.02.18**

**“ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ”ХК-ИЙН 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилтууд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хэрэгжилт	Тайлбар
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг ажилчдад сурталчлах, энэ талаархи мэдээллийг чөлөөтэй авах нөхцлийг хангах	1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар,цахим хуудас ажиллуулах,теле сурталчилгаа, яриа таниулга,сонсгол,өдөрлөг,хэлэлцүүлэг хийх/	жилдээ	ЗХНГ		
	1.2 Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, ажилчдад түгээх	жилдээ	ЗХНГ		
2. Шинээр боловсруулж буй бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ,тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан	2.1 Боловсруулж байгаа хууль, УИХ,ЗГ,ИХТХ-ын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд,олон нийт, сонирхогч бүлгийн санал,шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	жилдээ	ЗХНГ		
	2.2 Боловсруулж байгаа хууль, УИХ,ЗГ,ИХТХ-ын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		

санал солилцох	2.3 Хувь нийлүүлэгчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	жилдээ	ЗХНГ		
.Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	3.1 Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах	2 сард	ЗХНГ, ДХЭУХ		
	3.2 Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлэх /цахим хуудсаар эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр/	жилдээ	ЗХНГ, ДХЭУХ		
	3.3 Хийсэн хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлэх	жилдээ	ЗХНГ, ДХЭУХ		
4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	4.1 2016 оны жилийн төсөв, 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны жилийн төсвийн төслийг цахим хуудсандаа байршуулах	2 сарын 10, 4 сарын 1, 8 сарын 15-ны дотор	ЗХНГ, ХОТЭЗГ		
	4.2 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсандаа байршуулах бөгөөд сарын төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тухай мэдээллийг цахим хуудсандаа тогтмол байршуулж байх	4 сарын 1-ний дотор, тухай бүрт	ЗХНГ, НББГ		

	4.3 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах	4 сарын 1-ний дотор	ЗХНГ, НББГ		
	4.4 Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх	Өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт	ЗХНГ, ХОТЭЗГ		
	4.5 Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	жилдээ	ЗХНГ, НББГ		
	4.6 Концессийн зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нийтэд мэдээлэх	Батлагдсанаас хойш ажлын 14 хоногт	ЗХНГ, ХОТЭЗГ		
	4.7 Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх	Ажлын 14 хоногт	ЗХНГ, ХОТЭЗГ		
	4.8 Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад	Ажлын 14 хоногт	ЗХНГ, ХОТЭЗГ		

	мэдээлэл,концессийн зүйл,гүйцэтгэх ажил,үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах				
	4.9 Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр,тэтгэмж,төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	жилдээ	ЗХНГ,НББГ		
	4.10 Гадаадын зээл,тусламжаар хэрэгжиж буй төсөл,хөтөлбөр,түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ, ХОТЭЗГ		
	4.11 Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан компанийн 2016 оны төсөвт 10 сая төгрөг суулгаж батлуулах	2 сард	ЗХНГ, ХОТЭЗГ		
5.Чиг үүргийн дагуу байгуулж буй гэрээ, хэлцлийг ил тод,нээлттэй байлгах,олон нийтэд танилцах боломжоор хангах	5.1 Бүх төрлийн гэрээ,хэлцлийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		
	5.2 Дээрх гэрээ,хэлцлийг байгуулах журмыг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		
	5.3 Гэрээ,хэлцлийн нэр,тэдгээрийг байгуулсан огноо болон хүчинтэй байх хугацааг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		
	5.4 Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүх гэрээ,хэлцлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох	жилдээ	ЗХНГ		

6. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	6.1 Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах	Тухай бүр	ЗХНГ		
	6.2 Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Тухай бүр	ЗХНГ		
	6.3 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	Эхний хагас жилд	ЗХНГ		
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,ажил,үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах	2 сард	ЗХНГ, ХАХНГ		
	7.2 Тендерийн баримт бичиг,тендер шалгаруулалтыг явуулах журам,тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
	7.3 Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлах	Жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
	7.4 Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
	7.5 Худалдан авсан бараа,ажил,үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
	7.6 Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		

	7.7 Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан,дүгнэлт болон бусад хяналт,шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
	7.8 Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод,хувийн хэвшил,төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	жилдээ	ЗХНГ,ХАХНГ		
8. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	8.1 Ажилчдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх	жилдээ	ЗХНГ		
	8.2 Ажилчдын хариуцсан ажил,үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах.	жилдээ	ЗХНГ		
9. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага,иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих,үйл ажиллагаандаа татан оролцуулах	9.1 Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт,явц байдалд хяналт тавих,судалгаа ,дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх	1 удаа	ЗХНГ		
	9.2 Төрийн бус байгууллага,иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгах.	жилдээ	ЗХНГ		
	9.3 Хэрэгжүүлсэн ажил,хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл,цахим хуудсаараа мэдээлэх	жилдээ	ЗХНГ		
10. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг	10.1 Эрх бүхий албан тушаалтныг томилох, хууль тогтоомжийн дагуу зохих урамшуулал	2 сард	ЗХНГ		

хариуцан зохион байгуулах,уг асуудлаар АТГ-тай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	олгох				
	10.2 ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод болон ажил үүргийн хуваарьт тусгах	2 сард	ЗХНГ		
	10.3 АТГ-аас зохион байгуулсан сургалтад ЭБАТ-ыг хамруулах	жилдээ	ЗХНГ		
	10.4 ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлүүлэх	жилдээ	ЗХНГ		
11.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	11.1 Батлагдсан Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	жилдээ	ЗХНГ		
	11.2 Ёс зүйн дүрмийг сурталчлах арга хэмжээ зохиох	жилдээ	ЗХНГ		
	11.3 Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл бүрдүүлэх	жилдээ	ЗХНГ		
	11.4 Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	жилдээ	ЗХНГ		

	11.5 Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх	Тухай бүрд	ЗХНГ		
12. Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	12.1 Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхлэж болох ажлын жагсаалтыг гаргаж, ажилчдад танилцуулах	6 сард	ЗХНГ		
	12.2 Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар аил эрхлэх тохиолдолд зохих зөвшөөрөл олгуулах	Тухай бүрд	ЗХНГ		
13. Компанийн удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	13.1 Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх/цахим хуудсаар/	жилдээ	ЗХНГ		
	13.2 Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж г.м/-ийг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		
	13.3 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ		
	13.4 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах	жилдээ	ЗХНГ, НББГ		
14. Иргэдийн өргөдөл, санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх	14.1 Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах	жилдээ	ЗХНГ		



шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	14.2 Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх/утас, хайрцаг, дэвтэр, факс, цахим г.м/	жилдээ	ЗХНГ		
	14.3 Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авах цагийн хуваарь зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	жилдээ	ЗХНГ		
	14.4 Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвэлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх	Улирал тутамд	ЗХНГ		
15. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	15.1 Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлах	жилдээ	ЗХНГ		
	15.2 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	жилдээ	ЗХНГ		
16. АТГ-аас гаргасан шийдвэрийг биелүүлэх	16.1 АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл, шаардлага зэргийн биелэлтийг хангаж ажиллах	жилдээ	ЗХНГ		
17. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх	17.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, АТГ-т хүргүүлэх	2 сард	ЗХНГ		

	17.2 Хэрэгжилтийн тайланг 11 сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх	11 сарын 15-ны дотор	ЗХНГ		
--	--	----------------------	------	--	--

БОЛОВСРУУЛСАН: ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН ДАРГА, ЭБАТ

Ш.БАЯРХҮҮ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН

ГАЗРЫН ЗАХИРАЛ

С.ГАНБОЛД